



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2014 оны 02 сарын 11 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

**Тэмцээний нэгдсэн заавар
батлах тухай**

“Биеийн тамир, спортын тухай” Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14,3 дахь заалт, Засгийн газрын 2009 оны 05, 211 дүгээр тогтоолыг тус тус хэрэгжүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын нийт албан хаагчдын бие бялдарыг чийрэгжүүлэх, спортын ур чадварыг хөгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2014 оны аварга шалгаруулах 4 төрөлт тэмцээний нэгдсэн зааврыг хавсралт ёсоор баталсугай.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд спортын тэмцээнийг зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг Цагдан хорих 461 дүгээр ангийн дарга, дэд хурандаа Ц.Очгэрэлд, Хорих 421 дүгээр ангийн дарга, хурандаа Г.Тэрбиш нарт даалгасугай.


3. Дээрхи спортын тэмцээнд зарцуулагдах хөрөнгийг зохих журмын дагуу олгохыг Санхүү, үйлдвэр, хөрөнгө оруулалтын газар /хурандаа М.Хуягбаатар/-т зөвшөөрсүгэй.

4. Спортын 4 төрлөөр зохион байгуулагдах тэмцээнд албан хаагчдыг бэлтгэж, идэвхтэй оролцуулахыг Хорих анги, Шийдвэр гүйцэтгэх алба, Салбар нэгжийн дарга нарт үүрэг болгосугай.

ДАРГА, ХУРАНДАА

ХУУЛБАР ҮНЭН:

Захиргааны удирдлагын газрын
дарга, дэд хурандаа
2014.02.11



Д.ЯДАМДОРЖ

П.Гантөмөр

0000159

БАТЛАВ:
ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
ХУРАНДАА
Д.ЯДАМДОРЖ



**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН
2014 ОНЫ АВАРГА ШАЛГАРУУЛАХ 4 ТӨРӨЛТ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2014.02.07

1. Тэмцээний нэгдсэн зорилт:

Монгол Улсын Засгийн Газрын 2009 оны 05, 211 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд нийтийн биеийн тамирыг бүх нийтийн хүртээл болгох, биеийн тамир, спортыг таниулан сурталчлах, ажилтан, албан хаагчдын эрүүл мэндийг бэхжүүлэх, хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлж, бие бялдрыг чийрэгжүүлэх, спорт сонирхогчдын хүрээг өргөжүүлэх, биеийн тамир, спортын авъяастнуудыг тодруулах, тэднийг алдаршуулах зэрэгт оршино.

2. Тэмцээний агуулга:

2014 онд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хэмжээнд зохион байгуулах ба тэмцээнийг спортын 4 төрлөөр явуулж аваргыг шалгаруулна. Үүнд:

Д/д	Спортын төрөл	Бүсийн тэмцээний		Шигшээ тэмцээний огноо	Хариуцах албан тушаалтан
		байршил	огноо		
1	Гар бөмбөг	ШШГЕГ-ын спорт заал	4-6/IV	18-20/IV	Д/х П.Гантөмөр Д/х Н.Мөнхжаргал
2	Сагсан бөмбөг	ШШГЕГ-ын спорт заал	4-6/IV	18-20/IV	Х/а П.Хосбаяр А/х Д.Амгалан
3	Ширээний теннис	ШШГЕГ-ын хурлын заал	18-20/IV	18-20/IV	Х/а Б.Амардорж Д/х Ч.Хүрэлбаатар
4	Буудлага	Хорих 401-р ангийн буудлагын тийр	18-20/IV	18-20/IV	Д/х Б.Нямгомбо Д/х Б.Түвшинтөгс

3. Зохион байгуулагч:

Цагдан хорих 461 дүгээр анги, Хорих 421 дүгээр анги

Тэмцээний арга зүй:

Тэмцээн 3 үе шаттай явагдана. Үүнд:

1 дүгээр шатанд: Анги, алба, салбар нэгж нь зааварт тусгагдсан спортын төрлүүдээр өөрийн нэгжийн хүрээнд тэмцээнийг зохион байгуулж, оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулна. Зохиогдох тэмцээнийг уламжлалт, нэрэмжит, бооцоот болон ангийн аварга шалгаруулах зэрэг төрлөөр зохион байгуулж болно.

2 дугаар шатанд: Анги, алба салбар нэгжээс шалгарсан баг тамирчид бүсийн тэмцээнд оролцох бөгөөд тэмцээнийг бүсчилэн явуулна. Хуваарилсан бүсийн дагуу нэгжүүд бүсийн тэмцээнд оролцоно.

3 дугаар шатанд: Төрөл тус бүрд бүсээс шалгарсан эхний 2 баг шигшээ тоглолтонд оролцоно.

Төвлөрсөн хорих ангиуд:

1. Хотын "А" бүсэд:

2. Хотын "Б" бүсэд: "А" "Б" бүс шийдвэрлэгдээгүй, шигшээ тэмцээн Хорих 401 дүгээр ангид төвлөрч, тэмцээнийг Цагдан хорих 461 дүгээр ангийн дарга, дэд хурандаа Ц.Очгэрэл, Хорих 421 дүгээр ангийн дарга, Хурандаа Г.Тэрбиш нар хариуцан зохион байгуулж ажиллана.

3. "Баруун" бүсэд: Хорих 403, 433, 435, 439 дүгээр анги, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ аймгийн Мандал, Өвөрхангай аймгийн Хархорин сум, Хөвсгөл зэрэг аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албад багтана. Баруун бүсийн төв нь Орхон аймгийн ШГАлбанд төвлөрч, тэмцээнийг хурандаа М.Ариунболд хариуцан зохион байгуулж ажиллана.

4. "Зүүн" бүсэд: Хорих 415, 417 дугаар анги, Багануур, Говьсүмбэр, Хэнтий, Төв аймгууд дахь Шийдвэр гүйцэтгэх албад, Согтуурах, мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газар зэрэг нэгж багтана. Зүүн бүсийн төв нь Говьсүмбэр аймаг дахь ШГАлбанд төвлөрч, тэмцээнийг хошууч П.Батзориг хариуцан зохион байгуулж ажиллана.

5. Хуваарьт багтаагүй шийдвэр гүйцэтгэх албадаас байгууллагаасаа цэвэр баг гаргаж аймгийнхаа тухайн төрөлийн тэмцээнд медаль авсан тохиолдолд Захиргааны удирдлагын газарт мэдүүлгээ ирүүлж тэмцээнд оролцох асуудлыг шийдвэрлүүлж болно.

Тус тэмцээнийг тухайн байгууллага хариуцан зааварт тусгагдсан төрлөөр уламжлалт ба нэрэмжит зэрэг төрлөөр зохион байгуулна. Тэмцээнд шаардагдах хэрэглэл, материал, хөрөнгө, санхүүгийн асуудлыг тухайн байгууллага хариуцан зохион байгуулна.

4. Спортын төрлүүдийн заавар:

1. **Гар бөмбөг:** Байгууллагаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 8, нийт 16 тамирчин оролцоно. Эрэгтэй, эмэгтэй баг бүрийг шалгаруулж, эхний 3 байр эзлүүлнэ.

Шагнал:

I байр – 250.000
II байр – 200.000
III байр – 150.000

2. **Сагсан бөмбөг:** Байгууллагаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 7, нийт 14 тамирчин оролцоно. Эрэгтэй, эмэгтэй баг бүрийг шалгаруулж, эхний 3 байр эзлүүлнэ.

Шагнал:

I байр – 250.000
II байр – 200.000
III байр – 150.000

3. **Ширээний теннис:** Байгууллагаас эрэгтэй, эмэгтэй ганцаарчилсан төрлөөр оролцоно. Эрэгтэй, эмэгтэй тамирчин тус бүрийг шалгаруулж эхний 3 байр эзлүүлнэ.

Шагнал:

I байр – 100.000
II байр – 80.000
III байр – 60.000

4. **Буудлага:** Байгууллагаас эрэгтэй, эмэгтэй тус бүр 1, нийт 2 тамирчин оролцоно. Тэмцээн зөвхөн хийн гар бууны төрлөөр явагдана. Эрэгтэй, эмэгтэй тамирчин тус бүрийг шалгаруулж эхний 3 байр эзлүүлнэ.

Шагнал:

I байр – 100.000
II байр – 80.000
III байр – 60.000